

“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

Г **Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргах,
Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж гэж дүгнэсүгэй.
- Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитор Сэрэлт Дөл Аудит ХХК-иас өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
- Гурав. Энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралт дахь ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД



БУЛИГААР ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

ТУЗ нь өнгөрсөн оны ээлжит хурал дээр тус компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр компанийн дүрэм, журамд заасны дагуу тогтмол хяналтыг тавин, компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос 54% өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн.

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй байснаас бодит гүйцэтгэлээр 8,628.3 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөөг 78%-ийн биелэлтэй ханган ажиллаж, өмнөх оноос мөн үеэс 19.7%-ийн өсөлтийг үзүүлжээ. Монгол Улс дахь дотоод борлуулалт 7,412.2 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 88% буюу өмнөх оны мөн үеэс 28%-ийн өсөлтийг үзүүлсэн ба гадаад борлуулалт буюу экспортын хэмжээ мөнгөн дүнгээр 1,216.1 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 46%-д хүрсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 8% буурсан байна.

2024 онд нийт 653 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 92.7%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн тоног төхөөрөмж, 7.3%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтад зарцуулсан байна.

Хүний нөөцийн тогтвортой бодлого барих, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор бүтэц, орон тоог тогтвортой барьж, үйлдвэрлэлийн бүтээл, гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 141,923.41 хүн/цаг ажилласан нь өмнөх оноос 4% буурсан, цалингийн зардал 4% өссөн, нэг ажилтны дундаж цалин 8% өссөн үр дүнгийн тайлангаар нотлогдож байна. Энэхүү өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь үйлдвэрлэлийн нийт гарцын өсөлт болон нэгж түүхий эд болох бод малын арьсны дундаж талбайн хэмжээ байв. 2024 онд нийт үйлдвэрлэл өмнөх оноос 20.4%-иар өсөж, бод малын арьсны дундаж талбайн хэмжээ 2023 онд 182 дм.кв байснаас 2024 онд 221дм.кв болж даруй 21.4%-иар өссөн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагааны ашигт ажлын эффициент өсөж буйн илэрхийлэл гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг 2024 онд төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн бүхий л нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээл, орчин нөхцөлд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн ТУЗ-ийн зүгээс 2024 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “Хангалттай” гэсэн дүгнэлт өгч байна.